



СҮХБААТАР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 05 сарын 03 өдөр

Дугаар 12

Баруун-Урт

“Халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах аймгийн дэд хөтөлбөр”, төлөвлөгөө баталж, салбар дундын ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.12, Эрүүл мэндийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3, 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.2 дах заалт, Монгол улсын засгийн газрын 2017 оны 289 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах аймгийн дэд хөтөлбөр”-ийг нэгдүгээр, зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар, хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Дэд хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг жил бүрийн аймгийн нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган шаардагдах хөрөнгийг улс, орон нутаг, байгууллага, аж ахуй нэгжийн төсөв, гадаадын зээл тусламж, төсөлд хамруулан санхүүжүүлж үр дүнг хагас бүтэн жилээр тооцон аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдэд тайлагнаж байхыг Ажлын хэсэгт даалгасугай.

3. Харьяа нутаг дэвсгэртээ хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг аймгийн Засаг дарга, сумдын ИТХ, Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ИТХ-ын нарийн бичгийн дарга /А.Чулуунбат/-д даалгасугай.

ДАРГА

Б.МӨНХБАТ

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны  
05 дүгээр сарын 03 ний өдрийн 10 дүгээр  
тогтоолын нэгдүгээр хавсралт

## “ХАЛДВАРТ БУС ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ, ХЯНАХ АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨР”

### НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Халдварт бус өвчинтэй тэмцэх аймгийн дэд хөтөлбөрийн эрх зүйн үндэслэлийг Эрүүл мэндийн тухай хууль, Монгол Улсын Засгын Газрын 289 дүгээр тогтоол “Халдварт бус өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр”, Сүхбаатар аймгийн эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх дэд хөтөлбөр, Сүхбаатар аймгийн засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг гол баримт бичгүүдтэй уялдуулан боловсрууллаа.

НҮБ-ийн төрөлжсөн агентлагийн хамтарсан багаас 2015-2016 онд хийсэн үнэлгээгээр манай улсын хүн амын нийт нас баралтын шалтгааны 77 хувийг халдварт бус өвчлөл, тэдгээрийн 32 хувь нь 30-70 насныханыг хамран цагаас эрт нас барж байгааг тогтоожээ. Судалгаагаар энэхүү үзүүлэлтийг бага болон дунд орлоготой бусад оронтой харьцуулахад манай улс дэлхийд ХБӨ өндөр тархалттай 2 дахь орон болсон. Түүнчлэн өвчлөлийн архагшсан, хожуу үед өртөг өндөртэй оношлогоо, эмчилгээ хийж, үүнд эрүүл мэндийн салбарын төсвийн 70 гаруй хувийг зарцуулж байгааг дээрх үнэлгээгээр тогтоожээ.

Халдварт бус өвчний нас баралтын шалтгаан болсон эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын 2005, 2009, 2013 оны судалгаагаар 15-64 насны хүн амын 2 хүний 1 нь илүүдэл жин, таргалалттай, 3 хүний нэг нь цусны даралт ихсэлттэй, 4 хүн тутмын нэг нь хөдөлгөөний хомсдолтой, 2 эрэгтэйн 1 нь тамхи татдаг, 3 хүний 1 нь архи хэрэглэдэг, үүнээс 10 хүний 1 нь архийг хэтрүүлэн хэрэглэж байна. Мөн хүн амын 61.9 хувь нь цусан дахь холестерин хэмжээ ихэссэн буюу ихсэх эрсдэлтэй, 8.3 хувь цусан дахь сахарын өөрчлөлт( далд хэлбэр )-тэй байна. Түүнчлэн 3 ба түүнээс олон өвчний эрсдэлтэй хүн амын эзлэх хувь 10.5 хувиар нэмэгдсэн.

Нийгэм, эдийн засгийн эрчимтэй хөгжилтэй холбоотойгоор хот, суурин газрын хүн амын дунд шарилж лууль болон бусад хол газрын ургамлын цэцгийн тоосны шалтгаант амьсгалын замын харшил түгээмэл байна. Нийслэлийн оршин суугчдын дунд хийсэн судалгаагаар амьсгалын замын харшилтай хүмүүсийн 68,3 хувь шарилж, лууль, согоовор, ерхөг, хус, улиас зэрэг ургамлын тоосноос шалтгаалан өвчилсөн байна.

Сүхбаатар аймагт сүүлийн таван жилд бүртгэгдсэн нийт өвчлөлийн 96.3 хувийг халдварт бус өвчин эзэлж байна.Халдварт бус өвчний суурь шалтгаан болох шүд, гүйлсэн булчирхайн үрэвсэл, нүдний болон сонсголын эмгэгийн тархалт хүүхдүүдийн дунд өндөр байна.

Зонхилон тохиолдох халдварт бус өвчний эрт илрүүлгийн үзлэгт 2014-2017 онд артерийн гипертензи, чихрийн шижин хэв шинж 2 илрүүлгийн үзлэгт 47115 иргэн хамрагдаж батлагдсан артерийн гипертензи 956, батлагдсан чихрийн шижин хэв шинж 2–43 тохиолдол, хөхний үзлэгт 52143 хүн хамрагдан 10, умайн хүзүүний хавдар илрүүлэх эсийн шинжилгээнд 11004 хүн хамрагдан 13 хавдрын тохиолдол илэрсэн байна.


Хүснэгт 1. Сүүлийн дөрвөн жилийн эрт илрүүлэг үзлэгийн статистик үзүүлэлт

№	Он	Артерийн гипертензи, чихрийн шижин хэв шинж 2			Хөхний үзлэг		Умайн хүзүүний эсийн шинжилгээнд	
		Хамрагдсан хүн	Батлагдсан артерийн гипертензи	Батлагдсан Чихрийн шижин хэв шинж 2	Хамрагдсан хүн	Илэрсэн хавдар	Хамрагдсан хүн	Илэрсэн хавдар
	2014	11114	450	14	10602	0	2608	8
	2015	11360	198	10	13210	4	2746	3
	2016	12311	144	8	13915	3	2842	0
	2017	12330	164	11	14416	3	2808	2
	<b>Нийт</b>	<b>47115</b>	<b>956</b>	<b>43</b>	<b>52143</b>	<b>10</b>	<b>11004</b>	<b>13</b>

Сүүлийн таван жилийн статистик мэдээгээр хүн амын өвчлөлийн тэргүүлэх шалтгаандамьсгалын тогтолцооны өвчин 26.6 хувь, хоол боловсруулах тогтолцооны өвчин 20.9 хувь, цусны эрхтэн тогтолцооны өвчин 10.6 хувь, мэдрэлийн тогтолцооны өвчин 7.2 хувь, шээс бэлгэсийн тогтолцооны өвчин 6.9 хувийг эзэлж байна.

Хүснэгт 2. Сүүлийн таван жилийн хүн амын дундах тэргүүлэх өвчлөлийн үзүүлэлт


Өвчлөл/10000 хүн амд/	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он
Амьсгалын тогтолцооны өвчин	607	523	1492	1768	1780
Хоол боловсруулах тогтолцооны өвчин	759	830	1291	1038	948
Цусны эргэлтийн тогтолцооны өвчин	283	316	653	677	536
Мэдрэлийн тогтолцооны өвчин	189	270	480	431	305
Шээс бэлгэсийн тогтолцооны өвчин	382	231	350	304	547



Сүүлийн таван жилийн статистик мэдээгээр хүн амын насбаралтын шалтгааны 99.8хувийг халдварт бус өвчин эзэлж, үүнээс хавдар 30.6 хувь, цусны тогтолцооны өвчин 28.2 хувь, осол гэмтэл, хордлого гадны шалтгаант үхэл 10.4 хувь, хоол шингээх эрхтэн тогтолцооны өвчин 7.7 хувь, амьсгалын тогтолцооны өвчин 3.4 хувь байгаа нь нас баралтын тэргүүлэх шалтгаан ХБӨ-өөс үүдэлтэй байгаа нь харагдаж байна.

Хүснэгт 3. Сүүлийн таван жилийн нас баралтын тэргүүлэх таван шалтгаан

№	Өвчлөл /10000 хүн амд/	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он
1	Хавдар	17.6	20.9	17	15.6	16.5
2	Цусны эрхтэн тогтолцооны өвчин	19.7	15.2	15	15.6	15.5
3	Осол гэмтэл хордлого гадны шалтгаант өвчин	6.2	5.1	6	6.4	5.5
4	Хоол шингээх эрхтэн тогтолцооны өвчин	5.7	4.2	4	5.1	3.6
5	Амьсгалын тогтолцооны өвчин	1.8	1.6	2	1.7	2.3



Монгол Улсын Засгийн Газраас ХБӨ- өөс сэргийлэх, хянах нэгдүгээр хөтөлбөрийг 2005 онд, хоёрдугаар хөтөлбөрийг 2013 онд тус тус батлан олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлсний үр дүнд эрүүл мэндийн салбарт ХБӨ-өөс сэргийлэх эрт илрүүлэх тогтолцоо бүрдэж, улмаар зорилтот бүлгийн хүн амын 50 гаруй хувь нь урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх оношлогоонд хамрагдаж, хүн амын дунд архи, тамхинаас татгалзах, идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх зөв зохистой хооллох зэрэг амьдралын зөв дадал, нийгмийн хандлага төлөвшиж эхэлж байгаа зэрэг зэрэг үр дүн гарч байгаа боловч халдварт бус өвчин, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлийн тархалт өндөр хэвээр байсаар байна.

Дээр дурьдсан үндэслэл, шаардлагыг харгалзан Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор ХБӨ, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлсийн тархалтыг бууруулах чиглэлээр олсон ололтоо бататгах, байгууллага, хамт олон, нийгмийн салбар, олон улсын байгууллагын оролцоо, хамтын ажиллагааг сайжруулах, хүн амд чиглэсэн урьдчилан сэргийлэх тогтолцоог бэхжүүлэх, эрүүл мэндийн байгууллагын оролцоонд тулгуурлан ХБӨ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байгааг үндэслэн “Халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах аймгийн дэд хөтөлбөр”-ийг боловсруулав.

Хөтөлбөрийн хамрах хүрээнд хүн амын өвчлөл, нас баралтын зонхилох хувийг эзэлдэг, урьдчилан сэргийлэх боломжтой халдварт бус өвчин болох зүрх судасны өвчин, хавдар чихрийн шижин, бөөр уушгины архаг бөглөрөлтөт өвчин, хоол боловсруулах замын өвчин, яс, булчин, үе мөчний өвчин, сэтгэцийн өвчин тэдгээрийн анхдагч шалтгаан болох тамхи, архины хортой хэрэглээ, зохисгүй хооллолт, хөдөлгөөний хомсдол, уур бухимдал, халдварын бус гаралтай харшил болон зайлсхийж болох сохрол, дүлийрлээс урьдчилан сэргийлэх, түүнийг хянах асуудал орно.

## **ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА, ЗАРЧИМ**

2.1 Сүхбаатар аймгийн хүн амын дунд зонхилон тохиолдох халдварт бус өвчлөлийн тархалтыг иргэн, гэр бүл, байгууллага, хамт олон, нийгмийн олон талт хамтын ажиллагаанд тулгуурлан бууруулах, эрт үеийн хяналтыг нэмэгдүүлэн, тандалт судалгааг сайжруулах замаар эрсдэлт хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх зөв зан үйл төлөвшүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

2.2 Хөтөлбөрийн хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлнэ:

Зорилт 1. Хүн амын эрүүл аж төрөх мэдлэг, хандлагыг сайжруулах, байгууллага, аж ахуй нэгжид эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлэх замаар ХБӨ-д нөлөөлж байгаа эрсдэлт хүчин зүйлийн тархалтыг бууруулах;

Зорилт 2. ХБӨ-өөс урьдчилан сэргийлэх ажил болон эрт илрүүлэх, оношлогоо, эмчилгээний цогц тусламж, үйлчилгээг эрүүл мэндийн байгууллагын оролцоонд түшиглэн бэхжүүлж, өвчлөлийг эмчийн хяналтанд эрт авч, өвчлөл нас баралтын тоог бууруулах нөхцөл бүрдүүлэх;

Зорилт 3. ХБӨ, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлийг бууруулах чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг өргөжүүлж, ХБӨ-ий бүртгэл, мэдээлэл, тандалт, хяналт-шинжилгээ үнэлгээний тогтолцоог чанаржуулах;

Зорилт 4. ХБӨ-өөс урьдчилан сэргийлэх, хянахад орон нутгийн байгууллагын чадамж, манлайлал, засаглал нийгмийн бусад салбар, олон улсын байгууллагуудын оролцоо, хамтын үйл ажиллагааг сайжруулах;

2.3 Хөтөлбөрийг 2018-2021 онд дараах үе шаттай хэрэгжүүлнэ:

1 дүгээр үе шат: 2018-2019 он

2 дугаар үе шат: 2020-2021 он

## **ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР НӨЛӨӨ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**

3.1 Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ:

3.1.1. Хүн амын дунд зонхилон тохиолдох ХБӨ-ий шалтгаан, нийгэм, эдийн засгийн сөрөг нөлөөллийг иргэн, гэр бүл, хамт олон, аж ахуй нэгж, байгууллага салбар дундын оролцоотойгоор бууруулснаар өвчлөлийн тархалтыг эрт хязгаарлах, хүн амын амьдралын чанар сайжирч эрүүл аж төрөх зөв хандлага төлөвшинэ.

3.1.2. Хүн амын дунд зонхилон тохиолдож байгаа, хожуу үедээ өндөр өртөгөөр эмчлэгддэг хорт хавдар, цус харвалт, зүрхний шигдээс, чихрийн шижин зэрэг ХБӨ-ийг эрт илрүүлэн эмчлэх, нөхцөл бүрдсэнээр ХБӨ-ий шалтгаант нас баралт, өвчлөлийн тоо буурна.

3.1.3. Эрүүл мэндийг дэмжигч аж ахуй нэгж байгууллага, хамт олон, гэр бүл, сум болгох хөдөлгөөн өрнүүлснээр ажиллагчдын хөдөлмөрийн чадвар түр алдалт буурах нөхцөл бүрдэнэ.

3.1.4. Тогтвортой хөгжлийн хөтөлбөр, Сүхбаатар аймгийн Эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх дунд хугацааны стратегийн ХБӨ, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлийг бууруулах талаар дэвшүүлсэн зорилт хангагдах нөхцөл бүрдэнэ.

3.1.5. ХБӨ-ийг эрт илрүүлж, эмчилгээ үйлчилгээнд хамруулснаар өвчний хожуу үед шаардагдах өндөр өртөгтэй эмчилгээ, үйлчилгээний зардал буурах, эмнэлгийн ор хоног хасагдах, эрүүл мэндийн салбарын зардал хэмнэгдэнэ.

3.1.6. Хөдөлмөрийн чадвар алдалт буурснаар нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн зардал буурна.

3.1.7. ХБӨ-ийг эрт илрүүлэхэд шаардагдах зардлын тодорхой хувийг эрүүл мэндийн даатгалд хамруулснаар эрүүл мэндээ сахих хамгаалж, эмнэлгийн тусламж, үйлчилгээ аваагүй иргэд эрүүл мэндийн даатгалын үр шимийг хүртэх боломж бүрдэнэ.

3.1.8. Хүн амын цэвэр өсөлт нэмэгдсэнээр ажиллах хүчний тоо нэмэгдэж, эдийн засагт эерэгээр нөлөөлнө.

**3.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийн үр нөлөө, үр дүнг дараах шалгуур үзүүлэлтээр дүгнэнэ.**

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Эх үүсвэр	Суурь үзүүлэлт	Хүрэх үзүүлэлт	
					2019 он	2021 он
<b>Халдварт бус өвчний анхдагч эрсдэлт хүчин зүйлийн үзүүлэлт</b>						
1	Хүн амын тамхины хэрэглээ	Хувиар	*	25.1	24.0	23.0
2	Сүүлийн 30хоногт тамхийг 1-2 удаа хэрэглэсэн 13-15 насны хүүхэд	Хувиар	**	4.5	3.5	0
3	Сүүлийн 30хоногт тамхийг 1-2 удаа хэрэглэсэн 16-17 насны хүүхэд	Хувиар	**	15.9	10.0	0
4	Сүүлийн 30 хоногт ажлын байрандаа тамхины утаанд өртөгсөд	Хувиар	*	22.3	20.0	18.0
5	Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэгчид	Хувиар	*	7.9	7.0	6.5
6	Согтууруулах ундааг 1-2 удаа хэтрүүлэн хэрэглэж үзсэн сурагчид ,15-17 нас	Хувиар	**	9.5	4.0	0
7	25-64 насны хүн амын давсны хоногийн хэрэглээ/(гр/хоног)	Грамм	*	10.3	9.5	9
8	Хөдөлгөөний хомсдолтой хүн амын эзлэх хувь	Хувиар	*	38.6	35.0	30.0
<b>2. Халдварт бус өвчний завсрын эрсдэлт хүчин зүйлийн үзүүлэлт:</b>						
1	Илүүдэл жин, таргалалттай хүн амын эзлэх хувь(БЖИ≥25кг/м <sup>2</sup> )	Хувиар	*	52.2	50.0	45

2	Цусны даралт ихсэлт(артерийн дээд даралт $\geq 140$ , доод даралт $\geq 90$ ба даралт бууруулах эм хэрэглэж байгаа)-ийн тархалт	Хувиар	*	37.6	36.0	35.0
3	Цусан дахь нийт холестерины хэмжээ 5 ммоль/ л хэмжээтэй байгаа хүн амын эзлэх хувь	Хувиар	***	11.2	10	9.5
4	Захын цусан дахь глюкозийн 5,6-6,0 ммоль/л хэмжээтэй байгаа хүн амын эзлэх хувь	Хувиар	***	11.5	11	10.5
5	Цусан дахь глюкозийн хэмжээ ихэссэн(6,1 ммоль/л ба түүнээс их ), глюкоз бууруулах эм хэрэглэж байгаа хүн ам	Хувиар	***	2.3	2.1	1.8
3. Халдварт бус өвчний илрүүлэлт, өвчлөлийн үзүүлэлт :						
1	Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан хүн ам (30-60 нас)	Хувиар	***	71.9	80	85
2	Хөхний хорт хавдрын эрт илрүүлэх үзлэгт хамрагдах хүн ам (30-60 нас)-ын тоо	Бодит тоо	***	14416	15000	16000
3	Элэгний хорт хавдрын эрт илрүүлэх үзлэгт хамрагдсан хүн ам (40-65)-ын эзлэх хувь	Хувиар	***	62.2	80	90
4	Элэгний хорт хавдар эрт үе шатандаа оношлогдсон хувь(I,II үеийн эзлэх хувь)	Хувиар	***	28	40	45
5	Умайн хүзүүний хорт хавдар эрт шатандаа оношлогдсон хувь (I үеийн эзлэх хувь)	Хувиар	***	50	70	80
6	Цусны даралт ихсэх өвчинг эрт илрүүлэх үзлэг хамрагдсан хүн ам (40-64)	Хувиар	***	91.7	93	95
7	Чихрийн шижинг эрт эрт илрүүлэх үзлэгт хамрагдсан хувь хүн (40-64)	Хувиар	***	91.7	93	95
4. Хөтөлбөрийн үр нөлөөний шалгуур үзүүлэлт						
1	Хорт хавдраас шалтгаалсан нас баралт (10000 хүн амд)	Хувиар	***	15.5	15	14.5
2	Зүрх тогтолцооны шалтгаант нас баралт (10000 хүн амд)	Хувиар	***	14.3	14	13.3
3	Бөөрний сувганцрын	Хувиар	***	67.7	63	60

үрэвсэлт өвчний улмаас эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн үйлчлүүлэгч					
---	--	--	--	--	--

(\*) Халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлийн судалгаа, 2018 он

(\*\*) Сургуульд суурилсан өсвөр насны хүүхдийн архи тамхи хэрэглээний судалгаа, 2018 он

(\*\*\*) Эрүүл мэндийн үзүүлэлт, 2017 он

## **ДӨРӨВ . ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ**

5.1.1. Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

5.1.1 Улсын болон орон нутгийн төсөв

5.1.2 Гадаадын зээл, тусламж, төсөл хөтөлбөрийн санхүүжилт

5.1.3 Төр, хувийн хэвшлийн байгууллагын хамтын үйл ажиллагаа, төрийн бус байгууллага, иргэдийн тусламж хандив

5.1.4 Бусад эх үүсвэр

## **ТАВ. ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ**

6.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор байгуулагдсан ажлын хэсэг хариуцан, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллана.

6.2. Хөтөлбөрийн тухайн жилд хийсэн үйл ажиллагааны тайлан, үр дүнг тооцон мэдээлэх үүргийг аймгийн Эрүүл мэндийн газар хариуцан жил бүрийн 2 дугаар сард багтаан багтаан эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад тайланг хүргүүлнэ.

6.3. Хөтөлбөрийн дунд хугацааны үнэлгээг 2019 онд эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, орон нутгийн түвшинд үнэлгээг аймгийн Засаг даргын Тамгын газар хариуцан гүйцэтгэнэ.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны  
05 сарын 03-ний өдрийн 12 дүгээр  
тогтоолын хоёрдугаар хэвсрэлт

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч:

- Аймгийн Засаг дарга

Гишүүд:

- Засаг даргын орлогч

- Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

- Нийгмийн бодлогын хэлтсийн эрүүл  
мэнд, нийгмийн даатгалын бодлогын

асуудал хариуцсан мэргэжилтэн

- Эрүүл мэндийн газрын дарга

- Аймгийн нэгдсэн эмнэлгийн дарга

- Цагдаагийн газрын дарга

- Боловсрол соёл урлагийн газрын  
дарга

- Биеийн тамир спортын газрын дарга

- ГБХЗХГ-ын дарга

- Эрүүл мэндийн газрын Нийтийн  
биеийн тамир чийрэгжүүлэлт  
хариуцсан мэргэжилтэн

- Эрүүл мэндийн газрын Хоол тэжээл  
хүнсний аюулгүй байдал хариуцсан  
мэргэжилтэн

- Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн  
эрхлэгч

Нарийн бичгийн дарга:

- Эрүүл мэндийн газрын Халдварт бус  
өвчний сэргийлэлт, хяналт, хавдрын  
эрт илрүүлэг, үндэсний хөтөлбөр  
хариуцсан мэргэжилтэн

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны

05 сарын 03-ний өдрийн 12 дүгээр

тогтоолын гуравдугаар хавсралт

**ХАЛДВАРТ БУС ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ, ХЯНАХ АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ  
АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Үйл ажиллагааны чиглэл	Бүтээгдэхүүн	Шалгуур үзүүлэлт	Хариуцах	Хамтрах байгууллага	Хугацаа	Хүн/ өдөр	Төсөв
<b>Зорилт 1.</b> Хүн амын эрүүл аж төрөх мэдлэг, хандлагыг сайжруулах, байгууллага, аж ахуй нэгжид эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлэх замаар халдварт бус өвчинд нөлөөлж байгаа анхдагч болон завсрын эрсдэлт хүчин зүйлсийн тархалтыг бууруулах зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд:								
1.1	Сурагчдын эрүүл мэндийн үзүүлэлт боловсруулж, суралцагчдын эрүүл мэндийн байдлыг сайжруулах	Эрүүл мэндийн үзүүлэлт тогтоох, бүртгэх, мэдээний нэгдсэн цахим санг ашиглах	Эрүүл мэнд, БСШУС-ын сайдын тушаал	Бүх шатны эрүүл мэндийн байгууллага	ЭМЯ, ЭМГ	2018-2020	-	-
		Эмч, багш, сурагчдын мэдлэг, оролцоог сайжруулах, чадавхжуулах сургалтыг зохион байгуулах	Сургалт 4 Сурталчилгаа 500 хүн	ЭМГ	ЭМЯ, БСУГ, ГБХЗХГ	2018-2021	500 хүн	1.000.000
1.2	Тамхи, архи, ХБӨ-ний бусад эрсдэлт хүчин зүйл сэтгэгц нөлөөт бодисын /хэрэглээний хор уршиг, хөдөлгөөний хомсдол, сэтгэцийн эрүүл мэндийн асуудлаар мэдээлэл сургалт сурталчилгааг зохион байгуулах	Бусад салбар байгууллагын бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч нарт ухуулга нөлөөллийн сургалт сурталчилгааг зохион байгуулах	ЭМС-ын тушаал сургалтанд хамрагдсан байгууллагын тоо	ЭМГ	ЭМЯ АНЭмнэлэг, бүх шатны эрүүл мэндийн байгууллага Хэвлэл мэдээллийн хэрэгсэл	2018-2021	100 хүн	300.000
		Хүн амын зан үйлийн буруу зуршил, зан үйлийг өөрчлөх МСС-ны чиглэл, агуулга	ЭМС-ын тушаал, гэрээ байгуулсан хэвлэл мэдээллийн	ЭМГ	ЭМЯ, НЭМҮТ СЭМҮТ, БСУГ Хэвлэл	2018-2021	Жилд 1-2 байгууллага	500.000

		мэдээллийн арга тов тогтоон хэвлэл мэдээллийн байгууллагатай жилийн турш тогтмол сурталчлах гэрээ байгуулан ажиллах	байгууллагын тоо		мэдээллийн байгууллага			
		Эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтэн, нийгмийн ажилтан, өвчтөн болон биеийн тамирын арга зүйчдэд мэдлэг хандлагыг өөрчлөх сургалт зохион байгуулах	ЭМС-ын тушаал сургалтанд хамрагдсан мэргэжилтэний тоо	ЭМГ, АНЭ	НЭМҮТ, БСУГ, БТСГ	2018-2021	4 удаа 200 хүн	600.000
		ХБӨ-өөс урьдчилан сэргийлэх, нөлөөллийн арга хэмжээг аж ахуй нэгж албан байгууллагад мэргэшсэн эмч, мэргэжилтэн багц сургалт зохион байгуулах	Хамрагдсан хүний тоо	АНЭ, анхан шатны эрүүл мэндийн байгууллага	ЭМГ, ААНБ, ТББ	2019-2021	-	-
1.3	Архи тамхи сэтгэц нөлөөт бодисын хэрэглээг бууруулах, хянах үндэсний бодлогод тусгах, тайлагнах тогтолцоог бүрдүүлэх	Тамхины хяналтын суурь конвенци, НҮБ- ын төрөлжсөн агентлагын тамхины хяналтын үнэлгээ, зөвлөмжийг хэрэгжүүлэх	Төлөвлөгөө, тайлан, мэдээлэл	ЭМГ	ЭМЯ, бусад салбар байгууллага	2018-2021	-	-
		ДЭМБ-ын архины хэрэглээг бууруулах стратеги 10 чиглэлийг хэрэгжүүлэх, сурталчлах	Сургалт мэдээлэл	ЭМГ	ЭМЯ, холбогдох байгууллага	2018-2021	-	300.000
1.4	Мансууруулах эм сэтгэц нөлөөт бодисын хэрэглээг	Коломбо аргачлалыг орон нутагт хэрэгжүүлэх	Сургагч багш бэлтгэгдсэн тоо	АЗДТГ, ЭМГ	СЭМҮТ, Аймгийн нэгдсэн	2019-2021	60	2.500.000

	бууруулах КОЛОМБО хөтөлбөрийг хэрэгжүүлэх				эмнэлэг			
1.5	Халдварт бус өвчлөл, тэдгээрийн эрсдлийг бууруулах олон нийт, бусад салбар, байгууллагын идэвх, санаачлагыг өрнүүлэх	ХБӨ, тэдгээрийн эрсдлийг бууруулах талаар ААНБ, ТББ-ын дунд жижиг төслийн уралдаан зарлах, дүгнэх, үйл ажиллагааг сурталчилах	Хамрагдсан байгууллага хүний тоо	АЗДТГ, ЭМГ	ЭМЯ, НЭМҮТ, ААНБ, ТББ	2018-2021	-	600.000
		Өсвөр үе залуучуудын дунд “Архи тамхи бидний сонголт биш” хөдөлгөөнийг орон нутагт өрнүүлэх, олон нийтэд сурталчилах	Хамрагдсан байгууллага, хүний тоо	ЭМГ, ГБХЗХГ, БСУГ	НЭМҮТ, Хэвлэл мэдээллийн хэрэгсэл	2019-2021	12 байгууллага	-
		Архинаас гарсан хүмүүсийн хөдөлгөөний сурталчлах	Сургалтанд хамрагдсан хүний тоо	ЭМГ, АНЭ, Цагдаагийн газар	Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, ТББ	2018-2021	-	-
		“Давсгүй цай”, “Сахаргүй цай” аян зохион байгуулах	Зохион байгуулсан аян, оролцсон аймаг сумын тоо	АЗДТГ, ЭМГ, ХХААГ	Бүх шатны эрүүл мэндийн байгууллага ААНБ, ТББ	2018-2021	-	Шагналын сан 600.000
1.6	Архи тамхи хорт зуршлийн хор холбогдлыг сурталчилах ухуулга нөлөөллийн ажил зохион байгуулах	“Архи тамхины хор, үйлдвэрлэгчдийн бохир арга” сургалт сурталчилгаа зохион байгуулах	МСС-ны тоо	Бүх шатны эрүүл мэндийн байгууллага	ЭМГ, Цагдаагийн газар, Хэвлэл мэдээллийн байгууллага	2018-2021	20000 хүн	800.000

1.7	Тамхи, архи, согтууруулах ундааны хэрэгжилтийг эрчимжүүлэх хууль бус худалдааг илрүүлэх хяналт тавих	Тамхи архи,согтууруулах ундааны хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх ажлын хэсэг байгуулах, ажлын төлөвлөгөө гарган ажиллах	Уулзалтын тоо тайлан мэдээлэл	АЗДТГ, Цагдаагийн газар	ЭМГ, ГБХЗХГ	2018-2021	-	-
1.8	Архи, тамхи, бусад донтох эмгэгээс гарах хордлого тайлах эмчлэх тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах	Эрүүл мэндийн анхан шатны тусламжийг түшиглэн архи, тамхинаас гарах хүсэл төрүүлэх, хорт зуршлийг хаях зан үйлийг төлөвшүүлэх, багц сургалт зохион байгуулах	Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний байгууллага, сургалтын тоо	Анхан шатны эрүүл мэндийн байгууллага	ЭМГ, НЭМҮТ, СЭМҮТ,	2018-2021	-	-
		Архи, тамхинаас гаргах эмчилгээ, сургалт, зөвөлгөөнд эмнэлгийн байгууллага, мэргэжлийн холбоодын үйл ажиллагааг бий болгох	Сургалтын тайлан	ЭМГ, Аймгийн нэгдсэн эмнэлэг	ЭМЯ, СЭМҮТ	2018-2019	Хэлэлцүүлэг -1	120.000
		Архи, тамхи, мансууруулах бодисын хор хөнөөл, амиа хорлолтоос сэргийлэх сургалтын хөтөлбөр,гарын авлага боловсруулж, зөвөлгөө өгөх утас ажилуулах	Зөвөлгөө авсан хүний тоо	Аймгийн нэгдсэн эмнэлэг	СЭМҮТ, ЭМГ	2018-2021	-	-

		Архины хамаарлаас гарах эмчилгээ хийлгэсэн, гарахыг хүссэн хүн, тэдний гэр бүлийн хүмүүст туслах сайн дурын клуб, ТББ-д үзүүлэх арга зүйн дэмжлэг үзүүлэх	Сайн дурын клуб, хамрагдсан хүний тоо	АЗДТГ, ЭМГ, Аймгийн нэгдсэн эмнэлэг	Цагдаагийн газар, ГБХЗХГ	2018-2021	-	1.000.000
1.9	Давс, чихэр, тосны агууламж өндөртэй хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ, хэрэглээг, бууруулах	Эрүүл бус хүнсний сургалт сурталчилгааг тогтмол зохион байгуулах, эрүүл зөв хооллоход нөлөөлөх	Хамрагдсан хүний тоо	ЭМГ, Бүх шатны эрүүл мэндийн байгууллага	АЗДТГ, ХХААГ, Хэвлэл мэдээллийн хэрэгсэл	2018-2021	-	150.000
1.10	Давсны хэрэглээний тандалт судалгааг жил бүр үндэсний хэмжээнд хийж энэ чиглэлээр салбарын чадавхийг бэхжүүлэх	Бүх шатны эрүүл мэндийн байгууллагын мэргэжилтэнд хүн амд давсны хэрэглээний зөвөлгөө өгөх чадавхийг сайжруулах сургалт явуулах	Сургалт, хамрагдсан хүн, сургагч, багшийн тоо	ЭМГ	Бүх шатны эрүүл мэндийн байгууллага	2019-2020	200 хүн	400.000
1.11	Хүн амын хөдөлгөөний идэвхийг нэмэгдүүлэх, биеийн жингээ хэвийн хэмжээнд барих, илүүдэл жин, таргалалт, бие физиологийн зохицолдоог хянах, мэдээлэх, сурталчилгааг эрчимжүүлэх, үр	Хүний илүүдэл өөх, уураг, нүүрс ус, бие, физиологийн зохицолдоо, таргалалтыг тогтоох, хянах мэдээллийг бүртгэх, иргэнд зөвөлгөө өгөх, судалгаанд ашиглах, сургалт сурталчилгаанд ашиглах	Цахим сүлжээ сургалтын тайлан	ЭМГ, Бүх шатны эрүүл мэндийн байгууллага	ЭМЯ, БТСГ	2019-2020	-	-

	дүнтэй ажиллаж байгаа, иргэн, хамт олон байгууллагын үйл ажиллагааг	Хүн амын хөдөлгөөний идэвхийг нэмэгдүүлэх МСС зохион байгуулах	Сурталчилгааны цагын тоо	ЭМГ, БТСГ	ГБХЗХГ, БСУГ, Хэвлэл мэдээллийн хэрэгсэл	2018-2021	-	-
1.12	Боловсролын байгууллагыг түшиглэн сургуулийн хүүхдийн дундах архаг халдварын голомтыг эрт илрүүлэх, эмчлэх, халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлийг бууруулах арга хэмжээ авах	Сургуулийн сурагчдын архаг халдварын голомт /шүдний өвчлөл стрептококкын халдвар/ илрүүлэх эмчлэх, мэдээлэх, өөрсдийн хяналтанд авах төр хувийн хэвшлийн хамтын оролцоонд тулгуурлан хэрэгжүүлэх	Хамрагдсан хүүхдийн тоо	АЗДТГ, ЭМГ,АНЭ, Хувийн хэвшлийн эмнэлэг	ЭМЯ, БСУГ, ГБХЗХГ	2019-2021	-	-
		“Шүд эрүүл бол бие эрүүл” хөдөлгөөнийг өрнүүлэх	Хамрагдсан цэцэрлэг сургуулийн тоо	АЗДТГ, ЭМГ, БСУГ	Аймгийн нэгдсэн эмнэлэг, ААНБ	2019-2021	-	-
		Хүүхдийн сул хараа, харааны гажигийг 3, 6 насанд тогтмол шалгах бүртгэх мэдээлэх, харааг шалгах, хяналтанд авах, тогтолцоог цэцэрлэг сургууль түшиглэн хэрэгжүүлэх	Хамрагдсан хүүхдийн тоо	АЗДТГ, ЭМГ, бүх шатны эрүүл мэндийн байгууллага	БСУГ, ГБХЗХГ	2019-2021	-	-
		Сургуулийн эмч, нийгмийн ажилтан, биеийн тамирын багш, арга зүйч нарт илүүдэл жин таргалалттай хүүхдүүдийн эцэг эхэд хоол, хөдөлгөөний зөвөлгөө өгөх ур чадвар эзэмшүүлэх сургалт зохион байгуулах	Сургалт-4	ЭМГ, АНЭ, БТСГ	БСУГ, Хэвлэл мэдээллийн хэрэгсэл	2018-2019	-	500.000

		Бөөрний үрэвсэлт өвчний тархалтыг бууруулах зорилгоор сургуулийн хүүхдийн ариун цэврийн байгууламжийн хүртээмж /стандарт/-ийг сайжруулах	Стандарт ариун цэврийн байгууламжийн тоо	Аймаг сумын ЗДТГ, БСУГ	ЭМГ	2019-2021	-	-
1.13	Зонхилон тохиолдох ХБӨ-ий эрт илрүүлгийн товлосон үзлэг, шинжилгээнд иргэд зорилтот бүлгийн хамралтын хувийг нэмэгдүүлэх хяналтын тогтолцоо, эрүүлжүүлэх үйл ажиллагаа сайжруулах, эрт илрүүлгийн ач холбогдлыг иргэдэд таниулах	Хөх умайн хүзүү артерийн даралт, чихрийн шижингийн эрт илрүүлгийн хамрагдалт хангалтгүй байгаа шалтгааныг тодорхойлох судалгаа авах	Судалгаанд үндэслэн зөвлөмж боловсруулах	АЗДТГ, Баруун-Урт сумын ЗДТГ, ЭМГ	Бүх шатны эрүүл мэндийн байгууллага	2019-2020-	-	-
		Халдварт бус өвчний эрт илрүүлгийн үзлэг шинжилгээнд зорилтот бүлгийн хүн амын хамрагдалтын хувийг нэмэгдүүлэх талаар арга зүйгээр хангах	15 байгууллага	ЭМГ, АНЭ	Аймаг сумын ЗДТГ, өрх сумын эрүүл мэндийн төв	2018-2021	-	-
		Эрүүл мэндийн ажиллагсдын халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлэг, оношлогоо эмчилгээний талаарх мэдлэг чадварыг дээдлүүлэх	Сургалтын тоо	ЭМГ	АНЭ, өрх сумын эрүүл мэндийн төв	2018-2021	16 байгууллага	-
		Халдварт бус өвчний эрт илрүүлгийн үзлэг шинжилгээний ач холбогдлын талаар зорилтот бүлгийн хүн амд сурталчилах	Эрт илрүүлгийн хамрагдалтыг 90 дээш хувьд хүргэх	ЭМГ, Бүх шатны эрүүл мэндийн байгууллага	Төрийн болон төрийн бус байгууллага, хэвлэл мэдээллийн хэрэгсэл	2018-2021	-	-

		Ходоод, элэгний хорт хавдрын эрт илрүүлэг бүртгэл, мэдээлэл, хянах ажлыг зохион байгуулах	Хамрагдсан иргэдийн тоо	АЗДТГ, ЭМГ, АНЭ	Бүх шатны эрүүл мэндийн байгууллага	2018-2021	-	-
1.14	Сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал уур бухимдал сэтгэл гутралаас сэргийлэх тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах	Сэтгэлзүйн зөвөлгөө үйлчилгээг сургууль хамт олны түвшинд үзүүлэх сэтгэл зүйч, нийгмийн ажилтаны баг бүрдүүлэх	Хамтарсан баг байгуулах Хамрагдсан хүний тоо	ЭМГ, АНЭ, БСУГ, ГБХЗХГ, Цагдаагийн газар	СЭМҮТ	2019-2021	-	-
1.15	Зонхилон тохиолдох ХБӨ-ий сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ авах	Хүн амын суурьшилын газар дахь шарилж хөл газрын ургамлын тоосонцорын сөрөг үр дагаварыг эрт өрсөн арга хэмжээ бууруулах, зөвлөмж хүргэх	Зөвлөмжийн тоо	ЭМГ	Хот тохижилт үйлчилгээ	2018-2021	-	-
1.16	Ажлын байрны болон мэргэжлийн таагүй нөлөөллөөс үүдэлтэй ХБӨ-ий эрсдэлт хүчин зүйлийг бууруулах, хамт олон байгууллагын оролцоог идэвхжүүлэх	Ажилчидыг урьдчилан сэргийлэх үзлэгт тогтмол хамруулах	Хамрагдсан байгууллагын тоо	Аймаг сумын ЗДТГ, ААНБ	ЭМГ, АНЭ	2018-2021	-	-
		Зохистой хооллолт, хөдөлгөөний идэвхийг нэмэгдүүлэх үзүүлэх сургалт зохион байгуулах	Сургалт зохион байгуулах	ЭМГ, БТСГ, ГБХЗХГ	Төрийн болон төрийн бус байгууллага	2019-2021	1 жилд 6000 хүн	-
		Эрүүл мэндийг дэмжигч цэцэрлэг, сургууль, ажлын байр, сум болох хөдөлгөөнийг үе шаттай өргөжүүлэх, урамшуулах тогтолцоог бүрдүүлэх	Хөдөлгөөн өрнүүлэх	Аймаг сумын ЗДТГ, ЭМГ	ААНБ, БТСГ, Бүх шатны эрүүл мэндийн байгууллага	2019-2021	-	Орон нутгийн санхүүжилт ээр

		Эрүүл мэндийг дэмжигч ажлын байранд сургалт сурталчилгааг тогтмол зохион байгуулах	Эрүүл мэндийг дэмжигч байгууллагын тоо	ЭМГ, Бүх шатны эрүүл мэндийн байгууллага	Төрийн болон төрийн бус байгууллага	2018-2021	5000	-
<p><b>Зорилт 2.</b> Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх ажил болон эрт илрүүлэх, оношлогоо, эмчилгээний цогц тусламж, үйлчилгээг эрүүл мэндийн байгууллагын оролцоонд түшиглэн бэхжүүлж, халдварт бус өвчинтэй иргэнийг эмчийн хяналтанд эрт авч, өвчлөл нас баралтын тоог бууруулах нөхцөл бүрдүүлэх зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд:</p>								
2.1	Халдварт бус өвчнөөс сэргийлэх эмчлэх, хянах ажлыг эрхэлдэг эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийг сургалтанд хамруулах замаар мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх	Хавдрын эрт илрүүлгийн холбогдох хүний нөөцийг чадавхийг сайжруулах сургалтанд хамруулах	Сургагдсан эмч мэргэжилтний тоо	ЭМГ, АНЭ	Бүх шатны эрүүл мэндийн байгууллага	2020-2021	45	100.000
2.2	Зонхилон тохиолдож буй ХБӨ-ий эрт илрүүлгийн хүний нөөц, шаардагдах эм урвалж багаж, хэрэгсэл тоног төхөөрөмжийн хангамжийг үе шаттай нэмэгдүүлэх	Хүний амьдралын нас, хүйс мөчлөг бүрийн онцлогт тохирсон эрүүл мэндийн үзлэг, оношлогоо, шинжилгээ зөвөлгөөг цахим мобайл технологитой уялдуулах АШЭМБ-ыг мобайл технологичоор хангах ажлыг үе шаттай нэвтрүүлэх	Мобайл технолог нэтрүүлсэн АШЭМБ-ын тоо	АЗДТГ, Сумын ЗДТГ	ЭМГ, Анхан шатны эрүүл мэндийн байгууллага	2019-2021	-	Орон нутгийн хөрөнгө оруулалтаар
		Аймгийн түвшинд эрт илрүүлгийн багийг байгуулах, үйл ажиллагааг тогтмолжуулах /эхо, дуран, эмэгтэйчүүд, хавдар судлаач хавдар бүртгэгч, цитологич/	Эрт илрүүлгийн баг байгуулах	ЭМГ, АНЭ	Бүх шатны эрүүл мэндийн байгууллага	2018	-	-

		Өрх сумын ЭМТ-ийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг хөх умайн хүзүүний үзлэг, шинжилгээ авах шинэ арга барилд сургах	Сургагдсан эмч мэргэжилтний тоо	ЭМГ, АНЭ	Анхан шатны эрүүл мэндийн байгууллага	2018-2021	40	320.000
		Нийт хүн ам, жирэмсэн эмэгтэйчүүдийн артерийн гипертензи, чихрийн шижин хэв шинж-2, умайн хүзүүний хөх, элэг, ходооны хавдрын эрт илрүүлгийн хэрэгжилтэнд хяналт, шинжилгээ хийх, арга зүйн зөвөлгөө өгөх	Эрт илрүүлгийн хувь нэмэгдэнэ. Цахим хурлын хийсэн тоо	ЭМГ, АНЭ	Бүх шатны эрүүл мэндийн байгууллага	2018-2021	-	-
2.3	Уушигны архаг бөглөрөт өвчин, бөөрний үрэвсэлт өвчлөлийг эрт үед илрүүлэх, хяналтанд авах иргэдийн урьдчилан сэргийлэх, мэдлэг дадлыг сайжруулах, зөвөлгөө өгөх, ажлын чанар хүртээмжийг сайжруулах	Бөөрний үрэвсэлт өвчлөлийг эрт илрүүлэхэд хүний нөөцийн чадавхийг сайжруулах	Сургалтын тоо	ЭМГ, АНЭ	Бүх шатны эрүүл мэндийн байгууллага	2018-2021	200	400.000
		Иргэдийн урьдчилан сэргийлэх мэдлэг дадлыг сайжруулах МСС-ны ажил зохион байгуулах	Сурталчилгааны тоо	ЭМГ, Бүх шатны эрүүл мэндийн байгууллага	Хэвлэл мэдээллийн хэрэгсэл	2018-2021	1 жилд 10000 хүн	-
		Тулгуур хөдөлгөөний өвчнийг сум өрхийн түвшинд илрүүлэх /ясны сийрэгжилт, үений үрэвсэл/	Ясны сийрэгжилт, үений үрэвсэлтэй өвчтөний тоо	Анхан шатны эрүүл мэндийн байгууллага	ЭМГ, АНЭ	2018-2021	-	-
2.4	Зонхилон тохиолдох хавсарсан өвчний эмийн эмчилгээнээс бөөрний үйл ажиллагаанд үзүүлэх сөрөг	Мэдээлэл сургалт сурталчилгаа явуулах	МСС-ны тоо	ЭМГ, АНЭ	Бүх шатны эрүүл мэндийн байгууллага	2018-2021	200 хүн	Сургалтын зардал 400.000 төгрөг

	нөлөөллөлд хяналт тавих, эмч нарын мэдлэг ур чадварыг сайжруулах МСС хийх							
2.5	Хөнгөвчлөх тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах	Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээг гэрээр үзүүлдэг багийг эрүүл мэндийн байгууллагуудад байгуулж ажилуулах	Байгуулагдсан нэгжийн тоо	АНЭ, Анхан шатны эрүүл мэндийн байгууллага	ЭМГ	2018-2021	-	-
		Хөнгөвчлөх эмчилгээний талаар гэр бүл, олон нийтийн мэдлэг хандлага, дадлыг дээшлүүлэх гарын авлага, зөвлөмж гаргаж сургалт сурталчилгаа зохион байгуулах	Гарын авлага, зөвлөмжийн тоо Хамрагдсан иргэдийн тоо	АНЭ, Анхан шатны эрүүл мэндийн байгууллага	ЭМГ	2018-2019	1 жилд 1000 хүнд	-
2.6	ХБӨ, хүндрэлийг сэргээн засах тусламж үйлчилгээний талаар сум өрхийн эмч нарт сургалт зохион байгуулах	ХБӨ, хүндрэлийг сэргээн засах тусламж үйлчилгээний талаар сум өрхийн эмч нарт сургалт явуулах	Сургалтын тоо	ЭМГ, АНЭ	ЭМЯ, НЭМҮТ	2018-2021	100	200.000
2.7	Алслагдсан сум, багын хүн амд явуулын амбулаторийн төрөлжсөн нарын мэргэжлийн тусламж үйлчилгээг аймгийн нэгдсэн эмнэлэг зохион байгуулж, хэнийг орхигдуулахгүй байх зарчмаар эмнэлгийн тусламж	Алслагдсан хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг явуулын хэлбэрээр үзүүлэх	Үзлэг шинжилгээнд хамрагдсан хүний тоо	Аймаг сумын ЗДТГ, ЭМГ, АНЭ	Анхан шатны эрүүл мэндийн байгууллага	2018-2021		Орон нутгийн санхүүжилт

	үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх							
<b>Зорилт 3.</b> Халдварт бус өвчин, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлсийг бууруулах чиглэлээр эрдэм шинжилгээ , судалгааны ажлыг өргөжүүлж, халдварт бус өвчний бүртгэл, бүртгэл мэдээлэл тандалт, хяналт- шинжилгээ , үнэлгээний цахим, нээлттэй тогтолцоог орон нутаг, бусад салбар, үндэсний хэмжээнд бий болгох зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд:								
3.1	ХБӨ-ий эрсдэлт хүчин зүйлийн тархалтыг тогтоон шийдвэр гаргалтанд ашиглах	Сургуульд суурилсан хүүхдийн эрүүл мэндийн 3 дахь судалгаа хийх	Судалгааны тайлан	ЭМГ	ЭМЯ, БСУГ	2018-2019	-	-
		ХБӨ-ий эрсдэлт хүчин зүйлийн тархалтыг тогтоох 4 дэхь судалгааг хийх	Судалгааны тайлан	ЭМГ	ЭМЯ, Бүх шатны эрүүл мэндийн байгууллага	2018-2019	-	-
		Хоол тэжээлийн 6-р судалгааг хийх	Судалгаа хийгдсэн байх	ЭМГ	ЭМЯ, Бүх шатны эрүүл мэндийн байгууллага	2021	-	-
		Сүхбаатар аймгийн сахарын хэрэглээг тогтоох судалгаа	Судалгаа хийгдсэн байх	ЭМГ	ЭМЯ, Бүх шатны эрүүл мэндийн байгууллага	2021	-	-
		Хүүхэд өсвөр үеийн сэтгэцийн эрүүл мэндийн байдал, түүнд нөлөөлж байгаа эрсдэлт хүчин зүйлийн судалгааг хийх	Судалгааны тайлан	ЭМГ, АНЭ	ЭМЯ, бүх шатны эрүүл мэндийн байгууллага	2018	-	-
		Сэтгэл, гутрал, уур бухамдал, амиа хорлолтын шалтгаан, нөлөөлж буй эрсдэлт хүчин зүйлд судалгаа явуулах хэвлүүлэх	Судалгааны тайлан	ЭМГ, АНЭ	ЭМЯ, бүх шатны эрүүл мэндийн байгууллага	2019	-	-
<b>Зорилт 4.</b> Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, хянахад үндэсний болон орон нутгийн байгууллагын чадамж, манлайлал, засаглал болон нийгмийн бусад салбар, олон улсын байгууллагын оролцоо, хамтын үйл ажиллагааг сайжруулах зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд:								

4.1	ХБӨ-өөс сэргийлэх, хянах асуудлыг нийгмийн хөгжил, ядуурлыг бууруулах хөтөлбөр, төлөвлөгөөтэй уялдуулах	ХБӨ-ний нийтлэг болон нийгмийн эрсдэлт хүчин зүйлийг бууруулах асуудлыг нийгмийн салбарууд, орон тооны байгууллагын хөгжлийн хөтөлбөрт тусгах ажлыг зохион байгуулах	Тусгагдсан асуудлын тоо	АЗДТГ	ЭМГ	2019-2021	-	-
		Ядуу эмзэг бүлгийн иргэд, гэр бүлд ХБӨ, түүний эрсдлээс сэргийлэх хамт олонд суурилсан иртервенци хэрэгжүүлэх	Нэвтрүүлсэн интервенцийн тоо	ЭМГ	АЗДТГ, хөдөлмөр халамжийн төв, ГБХЗХГ, ААНБ	2019-2021	Интервенци-2	900.000
4.2		Хөтөлбөрийг хэрэгжүүлэх салбар дундын зохицуулах хороог байгуулах, ажлыг тогтворжуулах	Нэгжийн тоо	ЭМГ	АЗДТГ	2018-2021	-	-
		ХБӨ-өөс сэргийлэх, хянах өдөр тутмын үйл ажиллагааг зохицуулах салбар ажлын хэсгийг орон нутгийн ЭМГ-ын дэргэд байгуулах	Орон тооны бус нэгжийн тоо	ЭМГ	АНЭ	2019-2021	-	-
4.3	ХБӨ-өөс сэргийлэх хянах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд ААНБ, ТББ-ын оролцоог өргөжүүлэх ажлын үр дүн, оролцоог дэмжих	ХБӨ, эрсдэлт хүчин зүйлийг хянах хөшүүрэг, орчин бүрдүүлсэн, оршин суугчдыг идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэхийг дэмжсэн Засаг захиргааны санаачлагыг дэмжих	Хамрагдсан байгууллагын тоо	АЗДТГ, сумын ЗДТГ	ЭМГ, БТСГ	2018-2021	15	-

